



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
УЛСЫН БАЙЦААГЧИЙН
ШААРДЛАГА

2022 оны 1 сарын 13 өдөр

Дугаар 05/01

Улаанбаатар хот

ҮНЭТ ЭДЛЭЛИЙН ХУДАЛДААНЫ ТАЛБАЙ
ТҮРЭЭСЛҮҮЛЭГЧ АЖ АХУЙ НЭГЖ,
ҮНЭТ ЭДЛЭЛ ХУДАЛДАН БОРЛУУЛАГЧ НАРТ

Дэлхий дахинд тархаад байгаа коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын үед Монгол түмний үндэсний баяр “Цагаан сарын баяр” удахгүй болох гэж байгаатай холбогдуулан дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Халдвар хамгааллын дэмлэмээ чанд сахин, Улсын онцгой комиссоос гаргасан зөвлөмж, шийдвэрийг мөрдлөгө болгон ажиллах.
2. Худалдаанд байгаа дотоодын үйлдвэрийн үнэт эдлэл, мөнгөн аяганы сорьц холбогдох стандартын шаардлагад нийцсэн байх. /Засгийн газрын 281 дүгээр тогтоол, MNS 6505:2015 “Мөнгөн аяга-Ерөнхий шаардлага” /
3. Монгол улсад үйлдвэрлэсэн үнэт эдлэл нь үйлдвэрлэгчийн барааны тэмдэг, дор дурдсан сорьцын баталгааны тэмдэгтэй байж худалдан борлуулна.
Алтан эдлэл 333, 375, 585, 750, 916, 960, 999.
Мөнгөн эдлэл 800, 835, 875, 925, 999.
4. Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 150 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам”-ын 2.5.11-д худалдах үнэт металл, үнэт чулуу, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийг сорьцын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар сорьц тогтоолгон баталгаажуулсан байх.
5. Импортоор оруулж ирсэн гарал үүсэл нь тодорхой бус алт, мөнгөн үнэт эдлэлийг сорьцын шинжилгээнд оруулах, үйлдвэрлэгчийн гэрчилгээ, баталгаа бүхий бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулах.
6. Чулуун эдлэл худалдаалж байгаа иргэд үнэт чулуун эдлэлийг тодорхойлуулж гэрчилгээ авах, байгалийн, таримал, хиймэл чулуун эдлэлийн талаар үнэн зөв мэдээллээр хэрэглэгчдийг хангах, гарал үүслээр нь төрөлжүүлэн ялгавартайгаар худалдан борлуулах.
7. Бараа бүтээгдэхүүний шошгонд тавигдах мэдээлэл нь үнэн зөв, үйлдвэрлэгчийн нэр, тэмдэг, сорьц, жин, үнэ зэргийг агуулсан байна.
8. Худалдагч нарт үнэт металл, үнэт эдлэлийн сорьц, үнэт чулууны талаар өгсөн тайлбар, мэдээлэлийг лангуундаа байрлуулах.

Дээрх зөвлөмж шаардлагын хүрээнд 2022 оны 6 сарын 30-ны дотор худалдан борлуулж байгаа үнэт эдлэлүүдийг сорьцын шинжилгээнд бүрэн хамруулж, цаашид үнэт эдлэлүүдийг худалдан борлуулахдаа сорьцын баталгаанд хамруулж худалдан борлуулж байх талаар анхаарч хамтран ажиллана уу.

СОРЬЦЫН ХЯНАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА,
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



Д.БЭХБАТ